

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН
09-НЫ ӨДРИЙН 1/713 ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2023.12.07

Бүрд

№	Зөвлөмжийн утга	биелэлт	Оноо
1	Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтаныг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, тэднээс эрх үүргээ хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах	Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан уг ажлыг 9 жил хийж байгаа бөгөөд ЭБАТ-ын нэмэгдлийг 5 дугаар сарын 1-ээс 20 хувиар олгож эхэлсэн	100
2	Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж бичгээр мэдэгдэх, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар гаргаж хэвшүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах	Нийтийн албан тушаалтануудад аймгийн Засаг даргын зөвлөмжийг гарын үсэг зуруулан тарааж өгч танилцуулсан. Эрүүл мэндийн төвийн дарга туслах сувилагчаар суралцаж байсан Б.Анхтуяаг асрагчаар томилоход ашиг сонирхлын зөрчил үүссэн учраас мэдэгдэл тайлбараа сумын Засаг даргад гарган өгч шийдвэрлүүлсэн.	100
3	Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг/ ХАСХОМ/ гаргаж хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах	Нийтийн албанд шинээр томилогдсон 2 албан хаагч хуулийн хугацаанд буюу 30 хоногийн дотор ХАСХОМ-оо мэдүүлсэн.	100

4	<p>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүй томилдог, томилсоны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох</p>	<p>Ийм зөрчил гараагүй. Нийтийн албан тушаалд нэр дэвшин томилогдож байгаа Соёлын төвийн эрхлэгч Д.Азжаргал, Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Анхтөр нарын ХАСУМ-ийг АТГ-т хянуулж томилуулсан. Үзэх холбоос: http://burd.ov.gov.mn/%D1%85%D2%AF%D0%BD%D0%B8%D0%B9-%D0%BD%D3%A9%D3%A9%D1%86%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B8%D0%BB-%D1%82%D0%BE%D0%B4-%D0%B1%D0%B0%D0%B9%D0%B4%D0%B0%D0%BB</p>	100
5	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг чанд мөрдөж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль зөрчин хандив авч буй үйлдлийг нэг мөр таслан зогсоох, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахгүй байх</p>	<p>Хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хандив авахтай холбоотой хязгаарлалтыг мөрдөн ажиллаж байна.</p>	90
6	<p>Худалдан авах чиглэлээр мэргэшсэн ажилтан, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг олон давтамжтай хамруулахгүй байх, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх</p>	<p>2023 онд төрийн албан хаагчдаас 6 хүн танхимын сургалтад хамрагдан худалдан авах ажиллагаанд оролцох сертификат авсан. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагчдад давтан сургах ажлыг 2023 онд цахимаар 2 удаа зохион байгуулж, бүх шатны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, хөндлөнгийн хяналтыг сайжруулж ажилласан. 2023 онд 11 худалдан авалтад иргэний төлөөллийг оролцуулсан байна.</p>	100

7	Тендерт оролцогчдын эрхийг зөрчих, бусдад давуу байдал үүсгэх, тендерийг нэр төдий зохион байгуулж байгаад дүгнэлт хийх, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх	Сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шууд худалдан авахаар 7, Тендер шалгаруулалтын онцгой журмаар 4, олон нийтийн оролцоотой эзы аргаар 18, цахимаар 4 тендер зарлагдсан.	100
8	Засаг даргын нөөц хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаад дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг чангатгах, ялангуяа баяр ёслол, тэмцээн, уралдаан, наадам, шагнал, урамшуулал, дайллага, хүндэтгэл үзүүлэх, хайрхан тайх, буцалтгүй тусламж олгох зэрэг арга хэмжээнд уг хөрөнгийг зарцуулахгүй байх	Засаг даргын нөөц санд 28 сая төгрөг баталсан бөгөөд, 123 дугаар сарын 10-ны байдлаар 19,569.6 мян.төгрөгийг зарцуулаад байна. Зарцуулалтын 25 хувь нь зориулалтын дагуу , 75 хувь нь шагнал, уул овоо тахихад зарцуулсан байна.	70
9	Орон нутагт төрийн алба, төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн намын нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах нөхцөл бүрдүүлэх, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон хориглолт, хязгаарлалтыг зөрчихгүй байх	Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн хориглолт, хязгаарлалтыг төрийн албан хаагчид мөрдөн ажиллаж байна.	100

10	Төсвийн хэтрэлт, хэмнэлт, үр ашигтай байдлыг нарийвчлан тооцож, шаардлагагүй зардлыг тэвчих, “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг төрийн бүх шатны байгууллага, нэгжийн түвшинд хангуулан ажиллахад анхаарах , түүнд тавих хяналтыг сайжруулах	Сумын төсвийн хэрэгжилтийг зохион байгуулж түүнд байнгын хяналт тавьж аль болохоор үр өгөөжтэй хэмнэлттэй ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласнаар 2023 оны төсвийн жилд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ЗДТГ 140,926.2 мянган төг, Багийн засаг дарга 8,576.2 мянган төгрөг, ИТХуралд 24,756.6 мянган төгрөг, ЭМТ 1,555.0 мянган төгрөгийг тус тус хэмнэлт гаргахаар байна. 2023 онд төрийн албан хаагчдаас 6 хүн танхимын сургалтад хамрагдан худалдан авах ажиллагаанд оролцох сертификат авсан. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагчдад давтан сургах ажлыг 2023 онд цахимаар 2 удаа зохион байгуулж, бүх шатны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, хөндлөнгийн хяналтыг сайжруулж ажилласан. 2023 онд 11 худалдан авалтад иргэний төлөөллийг оролцуулсан байна.	100
		Бүгд	96